


2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЙЛАН

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалыг тус тус мөрдлөг болгон салбарын хэмжээнд цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих шийдвэр гаргуулан хуулийн хугацаанд нь хариуг өгч ажиллалаа.

Нэг. Батлан хамгаалах салбарын хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2022 оны 3 дугаар улиралын байдлаар Батлан хамгаалах салбарын хэмжээнд нийт 4278 өргөдөл, гомдол ирүүлснээс 3911 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилт 91.4 хувьтай байна. Энэ оны 3 дугаар улиралд багтаж шийдэгдээгүй, шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа хугацаа болоогүй 111 өргөдөл байгаа бөгөөд харьяа байгууллага, тухайн асуудал хариуцсан албан тушаалтанд 256 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шилжүүлж, холбогдох арга хэмжээг авсан байна. Батлан хамгаалах салбарын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.



Албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг дараах сувгаар хүлээн авч, ажилласан. Үүнд:

1. БХЯ-ны “Иргэд хүлээн авах байр”-нд биечлэн;
2. 458929 дугаарын утсаар;
3. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс цахим хэлбэрээр;
4. Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаараар, шуудангаар, цахим хуудас, олон нийтийн сүлжээ, албаны цахим хаягаар хүлээн авч,

бүртгэл хөтлөлтийг хийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлсэн байна.

2022 оны 3 дугаар улиралд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан сувгуудаар нь ангилбал:

- 3881 буюу 90,7 хувь нь бичгээр;
- 26 буюу 0,6 хувь нь ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс;
- 44 буюу 1 хувь нь “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаараар;
- 31 буюу 0,7 хувь нь цахимаар;
- 32 буюу 0,7 хувь нь ажлын утсаар болон бусад хэлбэр;
- 264 буюу 6 хувь нь биечлэн уулзсан байна.

Өргөдлийг агуулгаар нь ангилбал:

- | | |
|--|----------------------|
| 1. Нийгмийн хамгааллын асуудлаар | 1303 буюу 30,4 хувь; |
| 2. Ажлын байртай холбоотой асуудлаар | 1925 буюу 44,9 хувь; |
| 3. Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцах | 216 буюу 5 хувь; |
| 4. ЭДА-ны сонгон шалгаруулалттай холбоотой | 213 буюу 4,9 хувь; |
| 5. Ахмад дайчинтай холбоотой асуудлаар | 13 буюу 0,3 хувь; |
| 6. Бусад асуудал 608 буюу 14,1 хувийг тус тус эзэлж байна. | |

Ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын дийлэнх буюу 75,3 хувийг цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан алба хаагчдаас ирүүлсэн ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах болон нийгмийн хамгааллын асуудал, хүүхдийн цэцэрлэг болон гадаад, дотоодын их дээд сургуульд суралцах сонгон шалгаруулалтад оролцох, ажлаас чөлөөлөгдөх, өөр албан байгууллагад шилжин ажиллах эзэлж байгаа юм.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын дийлэнх хувийг нийгмийн хамгааллын асуудалтай холбоотой өргөдөл эзэлж байна.

Нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдлийг судлан үзэхэд тодорхой хугацаа шаардсан, тухай бүрт нь шийдвэрлэхэд хүндрэлтэй /албан тушаалын орон сууц олгуулах, мөнгөн дэмжлэг хүссэн г.м/ өргөдлүүд байгаа бөгөөд эдгээрийг тусгайлан бүртгэж, дараалалд оруулах арга хэмжээг авч, хариуг хүргүүлэн ажиллаж байна.

Хоёр. Батлан хамгаалах яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах яамны удирдлагад хандаж иргэдээс 244 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 226 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 12 өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн өгсөн бөгөөд хэрэгжилт 92.6 хувьтай байна. 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 6 өргөдлийг судалж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг албан тушаалтнуудад хандаж гаргаснаар нь харуулбал:

✓ Батлан хамгаалахын сайдад	50 буюу 20,4 хувь;
✓ Батлан хамгаалахын дэд сайдад	4 буюу 1,6 хувь;
✓ Төрийн нарийн бичгийн даргад	95 буюу 38,9 хувь;
✓ Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчид	1 буюу 0,4 хувь;
✓ Төрийн захиргааны удирдлагын газрын даргад	92 буюу 37,7 хувь;
✓ Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	1 буюу 0,4 хувь;
✓ Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	1 буюу 0,4 хувийг
тус тус эзлэж байна.	

Гурав. “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын **1800-1144** тусгай дугаарт иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн жинхэнэ алба хаагчидтай холбоотой бүхий л төрлийн санал, хүсэлт, мэдээллийг 24 цагаар тасралтгүй хүлээн авч байгаа бөгөөд 2022 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар “Батлан хамгаалах-Иргэний хяналт” 1800-1144 тусгай дугаарт 60 дуудлага ирснийг хүлээн авч 100 хувь шийдвэрлэсэн.

Тусгай дугаарын дуудлага хүлээн авах бүртгэлийн өдөр бүр хянан 7 хоног тутамд нэгтгэн Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчид танилцуулж холбогдох арга хэмжээг шуурхай авч байна.

Дөрөв. Бусад байгууллагаас харьяаллын дагуу уламжлагдан ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, яамны харьяа байгууллагуудаас 2022 оны 3 дугаар улиралд нийт 10 өргөдөл, гомдол шилжин ирснийг судлан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгч ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсын Их Хурал 2 буюу 22 хувь;
- Ерөнхийлөгчийн Тамгын газар 5 буюу 55 хувь;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 1 буюу 10 хувь;
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс 1 буюу 10 хувь;
- Монгол Улсын Боловсрол Соёл шинжлэх ухааны яам 1 буюу 10 хувийг тус тус эзэлж байна.

Тав. Өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг багасгах, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д заасны дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг богино хугацаанд шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд нь хариуг өгөхөд анхаарал хандуулан ажиллаж байна.

Иргэд, албан тушаалтнуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг газар дээр нь болон богино хугацаанд шийдвэрлэх боломжтой бол ихэвчлэн утсаар мэдэгдэх эсвэл албан бичгээр хүргүүлэх, БХЯ иргэд хүлээн авах байранд биечлэн уулзаж амаар хариуг нь аль болох түргэн шуурхай хүргэх хэлбэрийг сонгон ажиллаж байна.

Иргэдээс Батлан хамгаалах яам, удирдах албан тушаалтанд хандан өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргах, шийдвэрлэлтийн үйл явцыг хянах бололцоогоор хангах зорилгоор өргөдөл, гомдлын бүртгэлийг цахим системд шилжүүлэн иргэд, үйлчлүүлэгчидтэйгээ эргэх холбоотойгоор ажиллах зорилгоор Монголын Able soft компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Зургаа. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах
“11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн санал, хүсэлт,
гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2022 оны эхний хагас жилд Монгол Улсын Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс талархал 1, санал 11 гомдол, 14 хүсэлт хуваарилагдан ирсэн байна. Тус төвөөс хуваарилагдаж ирүүлсэн гомдол, хүсэлтийг тухай бүрт нь хүлээн авч тодотгон, холбогдох арга хэмжээг авч, хариуг өгч ажилласан.

Мөн Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэн тогтоосонд хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

Долоо. Байлдаанд оролцсон ахмад дайчид, тэтгэвэр, чөлөөнд байгаа
ахмад дайчид, тэдгээрийн гэр бүлээс ирүүлсэн хүсэлтийг
судлан нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн талаар:

Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Ардын болон гавьяат цолтон, Төрийн шагналт, Төрийн соёрхолт, Ахмад дайчин, Улсын ударник, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүдэд сар бүр нэмэгдэл олгодог.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар уг нэмэгдлийн санхүүжилтийг нийгмийн халамжийн сангаас хасч, тухайн ахмад настны шагнагдсан алдар цолны харьяалах салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусган баталсны дагуу Батлан хамгаалах салбарын харьяаны 61 алдар цолтон, ахмад настуудад нэмэгдэл мөнгөн дэмжлэгийг хуулийн дагуу сар бүр олгож байна.

2022 оны 3 дугаар улиралд 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Цэрэнгийн Чимэдцэрэнд зуурдаар нас барсан тул тэдний ар гэрт 100,000 (нэг зуун мянга) төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон.

Найм. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зарим алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдлын талаар:

Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан “Бэлтгэл болон чөлөөнд байгаа Монгол Улсын генерал цолтонд орон сууц, түүний үнийн дүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх журам”-ыг үндэслэн Монгол төрийн батлан хамгаалах бодлого, цэргийн шинэчлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж, орчин цагийн Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан чөлөөнд байгаа хошууч генерал Дашийн Магсаржавт орон сууцны дэмжлэг үзүүлэх зориулалтаар 40 сая төгрөг, мөн БХЯ-ны СБТГ-ын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга хурандаа Д.Энхсайханд ОХУ-д эмчилгээний зардалд зориулж 30 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус олгосон.

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын харьяа Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305, 321, 328 дугаар тусгай ротуудад албан тушаалын 8 айлын нийт 24 айлын орон сууцыг шинээр барьж ашиглалтанд оруулж офицер, ахлагч нарын нийгмийн хамгаалалд дэмжлэг үзүүлэн ажилласан.

Мөн Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085, 325 дугаар тусгай ротуудын байрны халаалтыг орон нутгийн төвлөрсөн халаалтын системд холбож офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Дүгнэлт:

2022 оны 3 дугаар улиралд Батлан хамгаалах салбарт алба хааж буй цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, зохих шийдвэрийг гаргуулан, хуулийн хугацаанд хариуг шуурхай өгөх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргах, шийдвэрлэлтийн үйл явцыг хянах бололцоогоор хангах зорилгоор өргөдөл, гомдлын бүртгэлийг цахим системд шилжүүлэн ажиллаж байна.

Батлан хамгаалах яам, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтыг зохих түвшинд хангасан гэж үзэж байна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД 2022 ОНЫ
3 ДУГААР УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ
ТӨРЛӨӨР НЬ АНГИЛСАН БАЙДАЛ**

Нийт 4278 өргөдлөөс:	
Хүсэлт	4220 (98,2%)
Санал	45 (1 %)
Гомдол	11 (0,25%)
Талархал	2 (0,04%)
Нийгмийн хамгааллын асуудлаар	1303 (30,4)
Ажлын байртай холбоотой асуудлаар	1925 (44,9)
Сургалттай холбоотой асуудлаар	216 (5 %)
Ахмад дайчинтай холбоотой асуудлаар	13 (0,3%)
ЭДА-ны сонгон шалгаруулалттай холбоотой	213 (4,9%)
Бусад	608 (14,1%)
<p>Байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасны дагуу Батлан хамгаалах салбарт цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд гарсан офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж буй байдлыг шалган, ирүүлсэн тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж илэрсэн зөрчил, дутагдлыг засуулж ажиллалаа.</p>	
<p>Албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг нийт 5 сувгаар /иргэдийг хүлээн авах байранд биечлэн; 458929 дугаарын утсаар; Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн; “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаараар; шуудангаар; яамны цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр/ хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилласан болно.</p>	
<p>Батлан хамгаалах салбарт цэргийн алба хаагч, тэтгэвэр чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан албан хаагч, иргэдээс ирүүлсэн өргөдлөөс шууд шийдвэрлэх боломжгүй удаан хугацаанд шийдвэрлэгдэх 91 өргөдөл шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна.</p>	
<p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дэх хэсэгт заасан “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана” гэж заасны дагуу богино хугацаанд шийдэх боломжтой өргөдлийг хуулийн хугацааг хүлээхгүйгээр богино хугацаанд шийдвэрлэн иргэнд хариу өгч ажиллаж байна. Үүний үр дүнд Батлан хамгаалах салбарт ирсэн нийт өргөдлийн 1-7 хоногт 40,6 хувийг, 8-14 хоногт 33,4 хувийг, 15-21 хоногт, 15,5 хувийг 22-30 хоногт 9,5 хувийг тус тус шийдэж хариуг өгсөн бөгөөд хуулийн хугацаа хоцроож шийдсэн өргөдөл, гомдол байхгүй байна.</p>	
<p>Иргэд, албан тушаалтнуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг ихэвчлэн албан бичгээр, шаардлагатай тохиолдолд биечлэн эсвэл харилцах утсаар аль болох түргэн шуурхай хүргэх хэлбэрийг сонгон ажилласан болно.</p>	
<p>“Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан шууд шийдвэрлэх боломжгүй удаан хугацаанд шийдвэрлэгдэх өргөдлийг тус зааврын 3 дугаар зүйлийн 3.3.7 дахь заалтын дагуу нэр төрөл, агуулга, харилцагчийн шинжээр нь бүлэглэн, дугаар өгч, бүртгэл хөтлөлт хийн хадгалж, шийдвэрлэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.</p>	
<p>Батлан хамгаалах салбарын хэмжээнд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн дийлэнх хувийг ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах болон нийгмийн хамгааллын асуудалтай холбоотой асуудал эзэлж байна.</p>	

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	БХЯ	4278	3911	256		111	91,4%

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	БХЯ	4278	3881	57	57	264	19

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

